



# ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ\*

2020 оны 7 дугаар сар

**Ерөнхий тойм:** Энэ оны эхний 7 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17%-иар буюу 1,348 сая ам.доллараар буурч 6,731 сая ам.доллар байв. Үүнд экспорт 17%-иар буюу 783 сая ам.доллараар, импорт 16%-иар буюу 565 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 218 сая ам.доллараар буурч 847 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 7 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2019/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,538	12,887	13,747	2,349	22%	861	7%	7,382	8,079	6,731	696	9%	(1,348)	-17%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	4,117	4,571	3,789	455	11%	(783)	-17%
Импорт	4,337	5,875	6,128	1,537	35%	253	4%	3,266	3,507	2,942	242	7%	(565)	-16%
Тэнцэл	1,863	1,137	1,492	(726)		355	31%	851	1,064	847	213	25%	(218)	-20%

**Валютын төлбөртэй худалдааны тэнцэл\*\*** 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 136 сая ам.доллараар буурч 980 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



**Хөрш орнуудтай хийсэн худалдааг** авч үзвэл, нийт бараа эргэлтийн 53% буюу 3,601 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 12% буюу 822 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 18%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 32%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



**Гадаад худалдааны нөхцөлийн индекс** 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 3%-иар, өмнөх сараас 7%-иар тус тус буурч 1.935-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх оны мөн үеэс буурахад чулуун нүүрсний экспортын үнэ болон нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ буурснаар тайлбарлагдаж байна. Харин өмнөх сараас буурахад хөрөнгө оруулалтын бараа болон нефтийн бүтээгдэхүүний импортын үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

\*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

\*\* Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

**Экспорт 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 17%-иар буюу 783 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 10 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 5 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 3 нэгж хувиар буурсан байна.**

**Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)			
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	
<b>1. Уул уурхай</b>		<b>3,636</b>	<b>88%</b>		<b>4,005</b>	<b>88%</b>		<b>3,546</b>	<b>94%</b>		<b>369</b>	<b>10%</b>	<b>9%</b>	<b>(459)</b>	<b>-11%</b>	<b>-10%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	848	1,176	29%	868	1,200	26%	794	876	23%	24	2%	7%	(324)	-27%	-7%	
1.2. Чулуун нүүрс	20,549	1,611	39%	20,807	1,788	39%	11,209	879	23%	177	1%	4%	(908)	-51%	-20%	
1.3. Боловсруулаагүй нефть	3,851	251	6%	3,726	211	5%	1,282	46	1%	(40)	-16%	-7%	(165)	-78%	-4%	
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	3,961	181	4%	4,835	311	7%	4,904	345	9%	130	72%	3%	34	11%	7%	
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	4%	4,665	196	4%	18,910	1080	29%	51	36%	7%	884	451%	19%	
1.6. Цайрын хүдэр, баяжмал	71	124	3%	83	122	3%	77	92	2%	(2)	-2%	0%	(29)	-24%	-7%	
1.7. Жонош, лейцит, нефелинт	240	79	2%	359	115	3%	370	88	2%	35	45%	7%	(27)	-23%	-7%	
1.8. Молибдений хүдэр, баяжмал	3	27	1%	3	29	1%	4	24	1%	2	8%	0%	(5)	-17%	0%	
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	3	0%	0	3	0%	0	0	0%	(0)	-12%	0%	(3)	-94%	0%	
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	-	0%	142,481	75	2%	(0)	-	0%	75	0%	2%	
1.11. Бусад	283	38	1%	93	31	1%	34	40	1%	(8)	-20%	0%	9	30%	0%	
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>254</b>	<b>316</b>	<b>8%</b>	<b>219</b>	<b>353</b>	<b>8%</b>	<b>148</b>	<b>144</b>	<b>4%</b>	<b>37</b>	<b>12%</b>	<b>1%</b>	<b>(209)</b>	<b>-59%</b>	<b>-5%</b>	
2.1. Амьд мал, малын мах	12	27	1%	14	27	1%	4	8	0%	(0)	-1%	0%	(19)	-69%	0%	
2.2. Арьс, шир	227	12	0%	189	10	0%	135	6	0%	(2)	-15%	0%	(4)	-42%	0%	
2.3. Малын өлөн гэдэс	0	4	0%	0	5	0%	0	5	0%	1	17%	0%	0	7%	0%	
2.4. Ноолуур	8	261	6%	7	299	7%	5	120	3%	38	15%	7%	(179)	-60%	-4%	
2.5. Ноос, бусад үс, хялгас	6	11	0%	6	11	0%	4	5	0%	0	3%	0%	(6)	-58%	0%	
2.6. Бусад	1	2	0%	3	2	0%	0	0	0%	(0)	-1%	0%	(1)	-74%	0%	
<b>3. Газар тариалан</b>	<b>18</b>	<b>4</b>	<b>0%</b>	<b>29</b>	<b>7</b>	<b>0%</b>	<b>24</b>	<b>7</b>	<b>0%</b>	<b>3</b>	<b>75%</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>1%</b>	<b>0%</b>	
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>166</b>	<b>160</b>	<b>4%</b>	<b>264</b>	<b>207</b>	<b>5%</b>	<b>139</b>	<b>92</b>	<b>2%</b>	<b>47</b>	<b>29%</b>	<b>1%</b>	<b>(115)</b>	<b>-56%</b>	<b>-3%</b>	
4.1. Хүнс	13	37	1%	14	34	1%	5	14	0%	(3)	-8%	0%	(20)	-58%	0%	
4.2. Ноолууран эдлэл	0	13	0%	0	19	0%	0	15	0%	6	44%	0%	(4)	-23%	0%	
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	2	7	0%	1	7	0%	2	7	0%	(0)	-4%	0%	1	8%	0%	
4.4. Уул уурхай	32	64	2%	93	61	1%	12	38	1%	(3)	-5%	0%	(23)	-38%	-7%	
4.5. Цахилгаан, электрон бараа	0	2	0%	0	1	0%	0	0	0%	(1)	-71%	0%	(0)	-21%	0%	
4.6. Машины механик, тоног төхөөрөмж, эд анги	2	34	1%	1	82	2%	1	15	0%	48	140%	7%	(66)	-81%	-7%	
4.7. Бусад	117	3	0%	154	4	0%	119	3	0%	1	35%	0%	(1)	-35%	0%	
<b>5. Бусад</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0%</b>	<b>(0)</b>	<b>-4%</b>	<b>0%</b>	<b>0</b>	<b>30%</b>	<b>0%</b>	
<b>Нийт дүн</b>		<b>4,117</b>		<b>4,571</b>			<b>3,789</b>			<b>455</b>	<b>11%</b>		<b>(783)</b>	<b>-17%</b>		

%<sup>2</sup> - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 7 сар**

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
<b>1. Уул уурхай</b>	<b>(101)</b>		<b>(358)</b>		<b>(459)</b>	<b>-11%</b>
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(81)	25%	(243)	75%	(324)	-27%
1.2. Чулуун нүүрс	(753)	83%	(155)	17%	(908)	-51%
1.3. Боловсруулаагүй нефть	(88)	53%	(77)	47%	(165)	-78%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	5	14%	29	86%	34	11%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	814	92%	71	8%	884	451%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	(7)	22%	(23)	78%	(29)	-24%
1.7. Жонош, лейцит, нефелинт	3	-10%	(30)	110%	(27)	-23%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	-42%	(7)	142%	(5)	-17%
1.11. Бусад	(69)	-745%	78	845%	9	30%
<b>2. Мал аж, ахуй</b>	<b>(78)</b>	<b>37%</b>	<b>(132)</b>	<b>63%</b>	<b>(209)</b>	<b>-59%</b>
2.1. Амьд мал, малын мах	(2)	113%	2	-13%	(19)	-69%
2.2. Арьс, шир	(21)	54%	(2)	46%	(4)	-42%
2.4. Ноолуур	(47)	26%	(132)	74%	(179)	-60%
<b>3. Газар тариалан</b>	<b>(1)</b>	<b>-1323%</b>	<b>1</b>	<b>1423%</b>	<b>0</b>	<b>1%</b>
<b>4. Аж үйлдвэрлэл</b>	<b>(284)</b>	<b>247%</b>	<b>169</b>	<b>-147%</b>	<b>(115)</b>	<b>-56%</b>
<b>5. Бусад</b>	<b>(0)</b>	<b>-239%</b>	<b>0</b>	<b>59%</b>	<b>0</b>	<b>30%</b>
<b>Нийт дүн</b>	<b>(465)</b>		<b>(319)</b>		<b>(783)</b>	<b>-17%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

**Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ**



2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулж, нийт 783 сая ам.долларын бууралтыг харвал:

1/ Уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 101 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 358 сая ам.доллараар буурчээ. Үүнд чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ болон үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 1,232 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн. Харин алтны экспорт нь тоо хэмжээний өсөлттэй холбоотойгоор өнгөрсөн оны мөн үеэс 884 сая ам.доллараар өссөн.

2/ Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын хувьд биет хэмжээний бууралтаас шалтгаалж 78 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан мөн 132 сая ам.доллараар буурсан.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 7 дугаар сард 1,846 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 30%-иар, өмнөх сараас 6%-иар өслөө. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 6,372; 109 ам.долларт тус тус хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 7%-иар өсч, төмрийн хүдэр 10%-иар буурсан. Харин өмнөх сартай харьцуулбал, зэсийн үнэ болон төмрийн хүдэр 11%, 5%-иар тус тус өсчээ. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 7 дугаар сард 74 ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 17%-иар, өмнөх сараас 9%-иар буурсан.

**Импорт 2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16%-иар буюу 565 сая ам.доллараар буурав. Импортын 16 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 7 нэгж хувийг, нефтийн бүтээгдэхүүний бууралт 6 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 3 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.**

**Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/**

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>	Дүн	Өсөлт	% <sup>2</sup>
<b>Хэрэглээний бүтээгдэхүүн</b>		<b>902</b>	<b>28%</b>		<b>967</b>	<b>28%</b>		<b>855</b>	<b>29%</b>	<b>65</b>	<b>7%</b>	<b>2%</b>	<b>(113)</b>	<b>-12%</b>	<b>-3%</b>
Түргэн эдлэгтэй	550	472	14%	506	482	14%	550	480	16%	9	2%	0%	(2)	0%	0%
Хүнс	270	328	10%	246	341	10%	265	337	11%	13	4%	0%	(4)	-1%	0%
Эм, тариа	2	65	2%	2	59	2%	2	62	2%	(6)	-9%	0%	3	5%	0%
Бусад түргэн эдлэгтэй бараа	279	80	2%	259	81	2%	283	81	3%	2	2%	0%	(1)	-1%	0%
Удаан эдлэгтэй	122	430	13%	206	485	14%	172	374	13%	56	13%	2%	(111)	-23%	-3%
Гутал, хувцас, цүнх	31	39	1%	42	37	1%	54	37	1%	(2)	-6%	0%	0	0%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	47	64	2%	114	63	2%	69	58	2%	(1)	-2%	0%	(5)	-7%	0%
Авто машин, түүний салбэг хэрэгсэл	1	281	9%	1	336	10%	1	228	8%	55	19%	2%	(108)	-32%	-3%
Бусад удаан эдлэгтэй бараа	43	45	1%	48	50	1%	49	51	2%	5	11%	0%	1	3%	0%
<b>Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн</b>	<b>943</b>	<b>1,317</b>	<b>40%</b>	<b>763</b>	<b>1,492</b>	<b>43%</b>	<b>840</b>	<b>1,252</b>	<b>43%</b>	<b>175</b>	<b>13%</b>	<b>5%</b>	<b>(240)</b>	<b>-16%</b>	<b>-7%</b>
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	17	823	25%	17	999	28%	20	775	26%	176	21%	5%	(224)	-22%	-6%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	1	274	8%	1	371	11%	5	249	8%	98	36%	3%	(122)	-33%	-3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	16	549	17%	16	628	18%	15	526	18%	79	14%	2%	(102)	-16%	-3%
Барилгын материал	438	374	11%	572	381	11%	731	341	12%	7	2%	0%	(40)	-10%	-1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	24	120	4%	25	112	3%	53	136	5%	(7)	-6%	0%	24	21%	1%
<b>Аж үйлдвэрлэлийн орц</b>	<b>888</b>	<b>438</b>	<b>13%</b>	<b>1,045</b>	<b>385</b>	<b>11%</b>	<b>1,019</b>	<b>377</b>	<b>13%</b>	<b>(54)</b>	<b>-12%</b>	<b>-2%</b>	<b>(7)</b>	<b>-2%</b>	<b>0%</b>
Хүнсний орц	262	69	2%	28	13	0%	129	34	1%	(56)	-81%	-2%	20	151%	1%
Химийн бүтээгдэхүүн	119	71	2%	130	69	2%	111	65	2%	(2)	-3%	0%	(4)	-6%	0%
Даавуу, утас, арьс, савжин эдлэл	42	17	1%	47	17	0%	38	14	0%	1	4%	0%	(3)	-19%	0%
Цахилгаан эрчим хүч	1	84	3%	1	83	2%	1	80	3%	(0)	0%	0%	(3)	-3%	0%
Металлын хүдэр, баяжмал болон хагдал	0	0	0%	1	0	0%	1	1	0%	(0)	-11%	0%	0	18%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	519	197	6%	556	201	6%	560	184	6%	4	2%	0%	(17)	-9%	0%
<b>Нефтийн бүтээгдэхүүн</b>	<b>888</b>	<b>604</b>	<b>18%</b>	<b>1,045</b>	<b>660</b>	<b>19%</b>	<b>1,019</b>	<b>456</b>	<b>15%</b>	<b>56</b>	<b>9%</b>	<b>2%</b>	<b>(204)</b>	<b>-31%</b>	<b>-6%</b>
Дизель түлш	487	317	10%	642	399	11%	544	235	8%	82	26%	3%	(165)	-41%	-5%
АИ-92, АИ-95	190	132	4%	274	164	5%	289	122	4%	32	24%	1%	(43)	-26%	-1%
А-80 болон бусад	211	155	5%	129	96	3%	186	99	3%	(59)	-38%	-2%	3	3%	0%
Бусад	12	4	0%	3	3	0%	153	3	0%	(1)	-21%	0%	(1)	-27%	0%
<b>Нийт дүн</b>		<b>3,266</b>		<b>3,507</b>			<b>2,942</b>			<b>242</b>	<b>7%</b>		<b>(565)</b>	<b>-16%</b>	

<sup>2</sup>% - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

**Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 7 сар**

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	26	-23%	(139)	123%	(113)	-12%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	201	-84%	(442)	184%	(240)	-16%
Аж үйлдвэрлэлийн орц	12		(19)		(7)	-2%
Нефтийн бүтээгдэхүүн	(5)	3%	(199)	97%	(204)	-31%
Дизель түлш	(42)	26%	(122)	74%	(165)	-41%
АИ-92, АИ-95	6	-14%	(49)	114%	(43)	-26%
А-80 болон бусад	30	1004%	(27)	-904%	3	3%
Бусад	2		(3)		(1)	-27%
<b>Нийт дүн</b>	<b>237</b>	<b>-42%</b>	<b>(802)</b>	<b>142%</b>	<b>(565)</b>	<b>-16%</b>

\* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг

**Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/**



2020 оны эхний 7 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт импорт 565 сая ам.доллараар буурчээ. Үүнд:

- Машин, механик тоног төхөөрөмжийн импорт буюу хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 240 сая ам.доллараар,
- Дизель түлшний хэрэглээтэй холбоотойгоор нефтийн бүтээгдэхүүний импорт 204 сая ам.доллараар,
- Хэрэглээний бүтээгдэхүүний импорт 113 сая ам.доллараар,
- Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 7 сая ам.доллараар тус тус буурчээ.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 41 хувиар буурсан хэдий ч өмнөх сараас 19 хувиар өсч тонн тутамд 368 ам.долларт хүрэв.